



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

Тэмдэглэлт өдрүүдийн үеийн тусламж,  
үйлчилгээг зохицуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалт, 2021 оны Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын А/126 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтээр тэмдэглэх тэмдэглэлт болон амралтын өдөр болох 2021 оны 11 дүгээр сарын 05-07, 11 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд ажиллах коронавируст (Ковид-19) халдварын эсрэг дархлаажуулалтын цэг, коронавируст (Ковид-19) халдварыг илрүүлэх шинжилгээний цэгийн ажиллах хуваарийг нэгдүгээр, төв салбарын шүд, дотор, хүүхэд, мэс засал, гэмтлийн кабинетэд ажиллах эмч, сувилагч нарын хуваарийг хоёрдугаар, Харуулын хуваарийг гуравдугаар, шуурхай хариу арга хэмжээний багийн ажиллах хуваарь, мэдээ авах албан хаагчдын нэрс, хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр буюу 2021 оны 11 дүгээр сарын 05, 26-ны тэмдэглэлт өдрүүдэд 09:00-15:00 цагийн хооронд мэс засал, гэмтэл, дотор, хүүхэд, шүдний кабинетыг ажиллуулах мөн Ковидын рентгентэй амбулаторийг 10:00-15:00 цагийн хооронд тус тус ажиллуулахыг Поликлиникийн эрхлэгч /Г.Цолмон/, Яармаг салбарын эрхлэгч /Г.Оюунцэцэг/ нарт үүрэг болгосугай.


- 2.1. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн коронавируст халдвар батлагдсан иргэдэд гэрийн хяналт, эргэлт хийх багийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг 2021 оны 11 дүгээр сарын 05, 26-ны тэмдэглэлт өдрүүдэд амрааж, амралтын өдрүүдэд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/100 дугаар тушаалд заасан хуваарийн дагуу тус тус ажиллуулахыг Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням/-даалгасугай.
- 2.2. Хүүхдийн амьсгалын замын өвчлөл, томуу, томуу төст өвчин, Ковид-19 халдварын эмчилгээ, асаргааны талаар зөвлөгөө өгөх утсыг 24 цагаар тогтмол ажиллуулах,
- 2.3. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтын цэгийг 2021 оны 11 дүгээр сарын 05, 26-ны өдрүүдэд амрааж, 11 дүгээр сарын 06, 27-ны өдрүүдэд хуваарийн дагуу ажиллуулж, вакцины нөөц болон бусад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах,
- 2.4. Коронавируст халдвар илрүүлэх шинжилгээний цэгийг хавсралтаар баталсан хуваарийн дагуу ажиллуулах, шаардагдах хувийн хамгаалах хэрэгсэл, сорьц, оношлуурын нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах,



- оношлуурын нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах,
- 2.5. Тэмдэглэлт болон амралтын өдрүүдэд ажиллах Тандалт, шуурхай хариу арга хэмжээний багийн ажиллах хуваарийг баталж, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, оношлуур, шатахуун тослох материалын нөөцийг бүрдүүлэх, нэмэлтээр ажиллах хүн хүч, автомашины бэлэн байдлыг хангах,
  - 2.6. Коронавирусын халдвар батлагдан гэрийн тусгаарлалтад байгаа иргэдэд тавих хяналтыг эрчимжүүлж, утсаар болон цахимаар тогмол холбогдож, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх,
  - 2.7. Түргэн тусламжийн үйлчилгээний бэлэн байдлыг хангах, яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун тослох материалын нөөцийг бүрдүүлэх, нэмэлтээр ажиллах хүний нөөц, автомашины бэлэн байдлыг хангах,
  - 2.8. Үндсэн тусламж болон коронавируст халдвартай иргэдийг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлдэг ор бүхий эрүүл мэндийн байгууллагууд орны нөөцийг бэлэн байлгах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардагдах иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх,
  - 2.9. Болзошгүй гамшиг, байгалийн аюулт үзэгдэл, хордлого, томоохон осол гэмтэл, тусламж, үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой ноцтой зөрчил гарсан тухай бүр газрын удирдлагад шуурхай мэдээлэх, шаардлагатай хариу арга хэмжээг цаг алдалгүй авах,
  - 2.10. Тусламж, үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, хүчилтөрөгч, хамгаалах хувцас хэрэгсэл, өвчтөний хоол, хүнсийг хүрэлцэх хэмжээгээр нөөцлөх, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, ажилчдын сонор сэрэмжийг дээшлүүлэх,
3. Осол гэмтэл, хоолны хордлого, угаарын хийн хордлого, осголт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлж ажиллахыг Ахлах тархвар судлаач /С.Өлзийжаргал/, яармаг салбарын эрхлэгч /Г.Оюунцэцэг / нарт тус тус даалгасугай.
  4. Тушаалыг хэрэгжүүлж тэмдэглэлт болон амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу амралтыг биеэр эдлүүлэх, батлагдсан төсөвтөө багтаан илүү цагийг тооцон олгохыг Хүний нөөцийн албаны дарга /Ц.Энхбаясгалан/-д үүрэг болгосугай.
  5. Тэмдэглэлт болон амралтын өдрүүдэд ажиллах эрүүл мэндийн байгууллагын байршил, цагийн хуваарь, холбогдох мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээ, байгууллагын цахим хуудсаар дамжуулан сурталчилж ажиллахыг мэдээлэл технологийн албаны дарга /А.Амартөвшин/-д үүрэг болгосугай.
  6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Т.Гэрэлсүрэн/, Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням/-нарт даалгасугай.


ДАРГА

Э.БОДЬЦЭЦЭГ





Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын  
 2021 оны 11 сарын 11-ны өдрийн  
 А/67... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



КОРОНАВИРУСТХАЛДВАР(КОВИД-19)-ЫН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ЦЭГИЙН  
 АЖИЛЛАХ ХУВААРЬ,

№	Цэгийн нэр байршил	Багын тоо	Ажиллах өдөр	Ажиллах эмч нарын нэрс Гар утасны дугаар	Албан тушаал
1	Соёлын ордны дархлаажуулалтын цэг	1	2021 оны 11 дүгээр сарын 05,06-ны өдрүүдэд тухайн өдрийн төлөвлөгөөний дагуу ажиллана	Т.Сэлэнгэ 88024656	Сүрьеэгийн эмч
				Ч.Уранчимэг 90113055	Сэргээн засах эмчилгээний сувилагч
				Д.Мэнджаргал 86670606	Сүрьеэгийн сувилагч
		1	2021 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр тухайн өдрийн төлөвлөгөөний дагуу ажиллана	Н.Лхагвадулам 99144919	Хүүхдийн эмч
				С.Навчаа 99740734	Шүдний сувилагч
				Д.Торноо 89895684, 91695586	Физик эмчилгээний сувилагч

КОРОНАВИРУСТХАЛДВАР(КОВИД-19)-ЫН ЭСРЭГ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН  
 АЖИЛЛАХ ХУВААРЬ,

№	Шинжилгээний Цэгийн нэр, байршил,	Багийн тоо	Ажиллах хүний тоо	Ажиллах өдөр
1	Буянт-Ухаа спорт цогцолборын гадаа талбай автобус	1	3	2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 07-ны өдрүүдэд 09.00-12.00 цагт, 11 дүгээр сарын 26-ын өдрөөс 28-ны өдрүүдэд 09.00-12.00 цагт



Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын  
 2021 оны ... сарын ... ны өдрийн  
 А/67... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

МЭС ЗАСАЛ, ГЭМТЭЛ, ДОТОР, ХҮҮХЭД, ШҮДНИЙ КАБИНЕТЫГ АЖИЛЛУУЛАХ  
 МӨН КОВИДЫН РЕНТГЕНТЭЙ АМБУЛАТОРТ 10:00-15:00 КАБИНЕТАД АЖИЛЛАХ  
 ЭМЧ, СУВИЛАГЧ НАРЫН ХУВААРЬ

Ажиллах кабинет	Ажиллах эмчийн нэр, утас	Ажиллах сувилагчийн нэр, утас	Ажиллах өдөр	Цагийн хуваарь
Гэмтэл, Мэс засал	С.Дүйнхэржав	С.Отгонсүрэн	2021.11.05	09:00-15:00
Шүд	С.Оюунчимэг	Уранчимэг		
Дотор	Ц.Отгонжаргал			
Хүүхэд	Ц.Ариунаа			
Рентгений их эмч	Б.Эрдэнэчулуун			
Гэмтэл, Мэс засал	Н.Габит	О.Отгончимэг	2021.11.26	10:00-15:00
Шүд	Х.Болор-Эрдэнэ	М.Нарантуяа		
Дотор	Д.Болормаа			
Хүүхэд	Н.Лхагвадулам			
Рентгений их эмч	Б.Эрдэнэчулуун			

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ХАРИУЦЛАГАТАЙ  
 ХАРУУЛААР АЖИЛЛАХ ХҮМҮҮС

№	Гарах он сар өдөр	Харуулын нэр	Утасны дугаар	Гарын үсэг
1	2021 оны 11 сарын 05, 26,	Алтанхуяг	95758993	
2	2021 оны 11 сарын 06, 27,	Гүррагчаа	88055923	
3	2021 оны 11 сарын 07, 28	Батболд	95013008	



Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын  
2021 оны 11 сарын 27-ны өдрийн  
107 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

2021 ОНЫ 11 САРД 24,48 ЦАГААР АЖИЛЛАХ, ШУУРХАЙ ХАРИУ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ БАГИЙН АЖИЛЛАХ ХУВААРЬ, МЭДЭЭ АВАХ АЛБАН ХААГЧДЫН  
НЭРС, ХУВААРЬ

№	Тандалт хариу арга хэмжээний мэдээний баг	Хангамж	Цагийн хуваарь	Тандалтанд ажиллах шөнийн ээлжний баг	Цагийн хуваарь
1	Б.Номин-Эрдэнэ	Б.Оюунсүрэн	24,48	Ц.Норовренчин	12,12
2	Г.Халиун	Б.Сүнжидмаа		Доржханд	
3	Г.Төрбат	Ц.Туяа		З.Эрдэнэчимэг	